



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-12

1. Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг үүрэг ажлаас нь чөлөөлөх тухай	4-12
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 11 дүгээр сарын 28-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 27 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 51.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 58 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Х.Баттулга, Д.Ганбат, У.Отгонбаяр, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Н.Алатнхуяг, М.Нарантуяа-Нара;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, П.Сайнзориг, Б.Тулга;

Тасалсан: Б.Дэлгэрсайхан, Г.Дамдинням.

Нэг.Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг үүрэг ажлаас нь чөлөөлөх тухай

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын дарга Н.Учрал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Л.Өлзийсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай саналыг Улсын Их Хурлын дарга Н.Учрал танилцуулав.

Улсын Их Хурлын даргын санал болон Үндсэн хуулийн цэцийн гишүүний хүсэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Д.Пүрэвдаваа, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Монгол Улсын Их Хурлын дарга Н.Учрал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Л.Өлзийсайхан нар хариулж, тайлбар хийв.

М.Номинчимэг: Улсын Их Хурлын гишүүн Лувсандоржийн Өлзийсайханыг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 2

Бүгд: 14

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 29 минут үргэлжилж, 27 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр 10 цаг 31 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 09 цаг 58 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Номинчимэг: Монгол Улсын Их Хурлын ХЗБХ-ны 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Ирц бүрдсэн тул хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн, Лхагвын Мөнхбаатар гишүүн, Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн, Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн, Давааын Цогтбаатар гишүүн, Баярмагнайн Баярбаатар гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн, Жудгийн Баярмаа гишүүн, Салдангийн Одонтуяа гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Гончигдоржийн Уянхишиг гишүүн нар ирсэн байна. Нийт 27 гишүүнээс 14 гишүүн ирж 51.9 хувийн ирцтэй байна аа.

Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, ҮХЦ-ийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай гээд нэг асуудал байна.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа орёе.

ҮХЦ-ийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

УИХ-ын дарга Ням-Осорын Учрал ҮХЦ-ийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай саналыг танилцуулна аа.

Одоо орж ирж байна уу?

Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учрал ҮХЦ-ийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай саналыг танилцуулна аа. Учрал даргад микрофон өгье.

Н.Учрал: ХЗБХ-ны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.1-д заасны дагуу ҮХЦ-ийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлыг ХЗБХ-нд танилцуулж байна аа.

Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт ҮХЦ 9 гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн 3-ыг Улсын Их Хурал, 3-ыг Ерөнхийлөгч, 3-ыг Улсын Дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно оо гэж заасны дагуу Лувсандоржийн Өлзийсайханыг Монгол Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 96 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын санал болгосны дагуу ҮХЦ-ийн гишүүнээр томилсон байна аа.

Лувсандоржийн Өлзийсайхан нь хууль тогтоох төлөөллийн дээд байгууллага болох Монгол Улсын Их Хуралд дэгийн асуудлаар зөвлөх, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах, хуульд заасан бусад ажлыг удирдан зохион байгуулж, хэрэгжүүлэх үүрэг бүхий Улсын Их Хурлын ЕНБД-ын албан тушаалд томилох Монгол Улсын Их Хурлын даргын саналыг хүлээн авсны үндсэн дээр 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр ҮХЦ-ийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн байна аа.

Монгол Улсын Их Хурлын дарга Хууль зүйн өндөр мэргэшил, төрийн албаны удирдах ажлын туршлагатай Лувсандоржийн Өлзийсайханыг Улсын Их Хурлын ЕНБД-ын албан тушаалд томилох нь зүйтэй гэж үзсэн болно оо.

Лувсандоржийн Өлзийсайхан нь 2019-2023 онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл явцад Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагын хувиар манлайлан оролцож Монгол Улсад Үндсэн хуулийн эрх зүйн шинэтгэлийг эхлүүлж хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмрийг оруулсан. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу парламентын эрх зүйн орчны болон бусад шинэтгэлийг гүнзгийрүүлж Монголд парламентын ардчиллыг бэхжүүлэх ард түмний засаглах эрхийг хангах чиглэлээр мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажиллаж ирсэн бөгөөд энэхүү мэдлэг, ур чадвар, туршлага нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амьдралд бодитой хэрэгжүүлэх үр нөлөөг сайжруулах асуудлаар чухлаар тавигдаж байгаа энэ цаг үед онцгой чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 105.1-д Цэцийн гишүүн бүрэн эрхийн хугацаа дуусахаасаа өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ анх илгээсэн байгууллагаараа уламжлан гаргасныг ХЗБХ хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд оруулна аа гэж заасны дагуу Монгол Улсын ҮХЦ-ийн гишүүн Лувсандоржийн Өлзийсайханыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Баярлалаа.

О.Номинчимэг: УИХ-ын даргад баярлалаа.

Гишүүдэд Улсын Их Хурлын даргаас ирсэн бичиг болон цэцийн гишүүний өөрийн хүсэлтийг бас тараасан байгаа. Ингээд энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт, үг хамт.

Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа.

Ирцийн дагуу Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж, үг хэлье.

С.Эрдэнэболд: Би бол одоо яг Монгол Улсын Их Хурлын гишүүний өргөсөн тангаргийнхаа өмнөөс, өргөсөн тангаргаа сахиж зарчмын асуудал хэлэх гэж байгаа юм аа. Үүнийг хувь хүн өөртөө тусгаж хүндээр битгий хүлээж аваарай.

Цэцийн хууль бол Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйл дээр маш тодорхой заасан. ҮХЦ түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна аа.

Цэцийн 1992 оны 5 сарын 8-ны хууль дээр ч гэсэн бол Цэц нь өөрөө Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхтэй байгууллага. Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн гээд. Миний итгэж үнэмшдэгээр бол Цэц бол Үндсэн хуулийн шүүх бөгөөд Цэц бол Үндсэн хууль гэдэг ард түмний язгуур эрхэмлэлийн эрхэм дээд тэр зүйлийн манаач байдаг.

Цэцийн гишүүнээс дээд албан тушаал, Дээд шүүхээс дээд албан тушаал гэж байхгүй гэж боддог. Өлзийсайхан Цэцийн гишүүнийг хувь хүнийх нь хувьд би асар хүндэтгэдэг. Манай сургуулийн багш. Таны бичсэн номуудыг уншиж бид нар үлгэр дуурайл авч, эмэгтэй тэр тусмаа хуулийн салбарт хүн ийм мундаг ажиллаж Монгол Улсын гавьяат хуульч болтлоо өөрийн чадавхаа дайчлан ажиллаж байгаагаар чинь үргэлж бахархаж ирдэг. Үүнийг бас цохон тэмдэглэе. 2023 оны 11 сарын 16-ны өдрийн 96 дугаар тогтоолоор та Цэцийн гишүүн болсон. Цэцийн гишүүний бүрэн эрх 6 жил. 2190 хоног.

Та бол өнөөдөр 3 жил 12 өдөр буюу 1107 хоног энэ ажлаа хийж байгаа. 50 хувь нь жоохон гараад явж байгаа гэсэн үг. Тэгэхээр Цэцийн гишүүн гэдэг тэр өндөр сэнтий, тэр өндөр хариуцлага, тэр өндөр Үндсэн хуулийн өмнө асар том үүрэг хариуцлагаа ингэж сольж байна аа гэдэг бол маш том буруу жишиг гэж харж байна. Энэ бол ер нь Цэцийн гишүүн гэдэг бол аливаа нэгэн улс төрийн суудал халаадаг тийм зай орон зай бол огт биш. Та нарын бидэнд заасан хичээл ч гэсэн тэгдэг биз дээ. Хуульчийн ёс зүй гээд.

Хоёрдугаарт дахиад хэлье. Би тангаргийнхаа өмнөөс ярьж байгаа хувь хүн дээр субъектив битгий хүлээж аваарай. Сая бас энэ Засгийн газар цэцийн шийдвэрээр үлдсэн тухай асуудал. Дөнгөж будаг нь хатаагүй байж байхад тэр шийдвэрийг гаргалцсан Цэцийн цэцийн гишүүдийн дундаас энд ийм шийдвэр гаргаж байгаа нь боломжгүй зүйл гэж харж байгаа.

О.Номинчимэг: Эрдэнэболд гишүүн нэг минут нэмж өгье.

Дараагийн үндэслэл Улсын Их Хурлын даргын урилгаар яг энэ тохиолдолд Учрал дарга бас эмзэг битгий хүлээж аваарай. Улсын Их Хурлы дарга бол намын дарга хийж байгаа. Шууд утгаараа цэцийн гишүүний шийдвэр гаргах процессоос гадна тэр хүн биеэрээ, үзэл санаагаараа, үйлдлээрээ үлгэрлэдэг. Гэтэл яг энэ одоо Цэцийн өндөр сэнтийгээс хугацааныхаа талд нь ингээд гарна гэдэг бол энэ цаашдаа буруу жишиг тогтоно оо. Цаана нь улс төр байгааг ойлгож байна. Мэдээж таныг туршлагатай мундаг хуульч хүн энэ ажлыг сайн хийгээд явчихна гэж итгэж үнэмшиж байгаа. Мэдээж цаана нь бас Монголын төлөө байгаа байх гэж найдаж байна. Гэхдээ энэ жишиг бол цаашид үргэлжилж болохгүй ээ.

Тэгэхээр танаас асуух асуулт нь болохоороо та энэ шийдвэрт хэр итгэл төгс байгаа юм бэ? Ёс зүйн хувьд энэ зөв үйлдэл мөн юм уу? Энэ дээр та тайлбар өгөөч? Нэр дэвшигч.

О.Номинчимэг: Хүсэлт гаргагч ҮХЦ-ийн гишүүн Өлзийсайхан. 5 номерын микрофоныг нээе. Асуултад хариулъя.

Л.Өлзийсайхан: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя аа.

Тэгэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт бол Үндсэн хуулийн 9 гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн 3-ыг бол Монгол Улсын Их Хурал, 3-ыг Ерөнхийлөгч, 3-ыг Улсын Дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно оо гэж хуульчилсан байгаа. Үндсэн хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурлаас надад өндөр итгэл хариуцлага хүлээлгэн 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр ҮХЦ-ийн гишүүнээр томилсон. Хуульч мөн Үндсэн хуулийн эрх зүй судлаач хүний хувьд энэ нэр төрийн хэрэг мөн. ҮХЦ оршин байгаагийн гол шалтгаан бол ерөөсөө ҮХЦ бол Үндсэн хуулийн баталгаа чандлан сахиулах баталгаа. Тэнд хүний эрх эрх чөлөөний эцсийн хамгаалалт нь өөрөө Үндсэн хуулийн цэц бол мөн.

Тэгэхээр энэ үзэл санаагаар бол ҮХЦ өөрчлөгдөн шинэчлэгдэж төлөвшлийг эрчимтэй хийж байгаа. Би энэ танхимд 2 жилийн өмнө хэлж байсан. Анх ҮХЦ-ийн гишүүнээр томилогдохдоо. Би хуульч мэргэжилдээ үнэнч байна аа. Би бас Үндсэн хуульдаа үнэнч байна аа гэж хэлж байсан. Энэ хуралдааны тэмдэглэлд тусгагдсан байгаа.

Тэгэхээр өнөөдөр ч гэсэн энэ үзэл бодол итгэл үнэмшлийнхээ төлөө би бас л хуульч мэргэжилдээ үнэнч. Үндсэн хуульд бас би үнэнч. Тийм учраас Монгол Улсын Их Хурлын даргын саналыг хүндэтгэн хүлээж авсан. Улсын Их Хурлын мэдээж ЕНБД гэдэг бол өмнө нь миний хашиж байсан энэ ажил албан тушаал бол Монгол төрийн залгамж чанар, парламентын уураг тархи болсон ийм байгууллага байсан. Одоо ч байгаа. Тэгэхээр энд хамгийн гол чухал зүйл юу вэ гэвэл Үндсэн хуулийг дагаж мөрдөх Үндсэн хуулийг дээдлэх ийм л зарчим үйлчилдэг. Тийм учраас Улсын Их Хурлын даргын саналыг бол бодсон. Гэхдээ надад маш бага хугацаа байсан, гэхдээ би шийдсэн итгэл үнэмшилтэй байна.

О.Номинчимэг: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн тодруулга нэг минут.

С.Эрдэнэболд: Би түрүүн 3 жил гэж 2 жил юм байна. Андуурч хэлсэн байна. Гол нь яах вэ Өлзийсайхан багш аа, хуульч аа гэж хэлэхэд хувь хүний итгэл үнэмшлээс асууж байгаа. Та хувь хүний хувьд итгэл үнэмшилтэй байгаа юм байна. Гэхдээ энэ бол жишиг бол сайн жишиг биш шүү. Одоо жишээлбэл Үндсэн хуулийн шүүх гэдэг шиг зүгээр Дээд шүүхээс нэг шүүгчийг татаж авчраад энэ чинь ЗГХЭГ-ын даргаар ч юм уу эс үгүй бол таны томилогдох гэж байгаа ажил дээр ч юм уу томилоод байдаг бол энэ институт гэдэг чинь маш эмзэг болно оо.

Яагаад гэхээр Цэц гэдэг бол бидний хувьд бол асар өндөр эрхэм дээд үйл хэргийн манаачид байхгүй юу. Тэгээд тийм өндөр сэнхий бөгөөд хариуцлага дээрээс хувийн шийдвэр энэ бол таны бие даасан шийдвэрийг хүндэтгэж байгаа ч гэсэн хувь хүн ингэж үзэж байна гээд шийдээд байх юм энэ бол цаашдаа маш буруу жишиг болно гэж үзэж байгаа шүү. Та дахиж бодож үзээрэй гэж хэлье.

О.Номинчимэг: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууж үг хэлье. Асуулт үг хамтдаа байгаа.

Д.Пүрэвдаваа: Өглөөний мэнд хүргэе ээ. Юун түрүүнд Улсын Их Хурлын дарга маань хуулийн чиглэлд мэргэшсэн боловсон хүчнийг Их Хурлын Тамгын газрын даргаар санал болгож байгаа нь нэг талдаа бол маш авууштай, сайшаалтай зүйл болж байна аа гэж харж байгаа. Цаашдаа Улсын Их Хурлаас гарах бүх шийдвэр өндөр түвшинд хууль зүйн хувьд хянагдаж гарах нь гэж баярлаж байгаа. Маш олон зүйлүүд ялангуяа өнгөрсөн хугацаанд сая төсөв батлагдахад гэхэд Ардын нам, АН 2 төсвийн ажлын хэсэг нэртэй 9 хүн огтхон нэг ч удаа хэлэлцэлгүйгээр зөвхөн санал хурааж Улсын Их Хурлаар шийдвэр гаргасан. Үндсэн хууль зөрчсөн иймэрхүү ноцтой зөрчил гаргахгүй байх гэж найдаж энэ хууль зүйн хувьд асар туршлагатай хүнийг оруулж ирж байгаа нь талархаж байгаагаа хэлье ээ. Хажуугаар нь бас нэг асуултууд байна аа.

Хувь хүний хувьд бол таныг маш сайн хүндэлдэг, хуульчийн хувьд мундаг хүн байх аа гэж бодож байна. Гавьяат хуульч хүн гэхээр. Тэгэхэд л нэг юм зэрэгцээд байна л даа. Миний санаж байгаагаар энэ ҮХЦ-ийн тухай хуульд нэг өөрөө чөлөөлөгдсөний дараа 3 жил ямар нэгэн албан тушаал хашихгүй байх нэг хууль зүйн зохицуулалт байдаг санагдаад байгаа юм. Тэр больчихсон уу байгаа юу? Тэрийг тэгэхдээ ер нь байсан тийм үү? Би яах вэ зүгээр дотроо бодож байгаа юм. Ер нь энэ Монгол Улсад улс төрийн намуудын нэр хүнд асар муу болсон. Ялангуяа эрх барьж байгаа нам идэвхгүй болсон мөрийн хөтөлбөрөө худлаа ярьдаг болсон. Тэгэнгүүт Цэцийн гишүүн гэдэг бол одоо Цэцийн дээр хөх тэнгэр буюу шударга үнэний туйл л байх ёстой гэж хардаг. Гэтэл одоо нэг ийм улс төржсөн субъектив тийм албан тушаал дээр л очих гээд байна шүү дээ. Тэгээд энэ чинь миний бодлоор бол энэ Цэцийн гишүүн 2-оос 3 жил ч гэдэг юм уу зарчмын хувьд ямар нэгэн төрийн болон бусад албан тушаал хашихгүй байх нь зүйтэй болов уу гэсэн ийм хувь хүний зарчимтай байдаг юм аа. Өмнө нь бас миний нэг уншиж байсан хууль дээр нэг тодорхой энэ төрийн алба хашдаг нөхдүүд тодорхой хугацаанд улс төрийн ялангуяа албыг хаших нь этикийн хувьд болохгүй гэсэн ийм хэм хэмжээ зохицуулалт байдаг санагдаад байсан. Тэгвэл тэр байхгүй болчихсон юм байна гэж ойлголоо.

Таны хувьд энэн дээр ямар байр суурьтай байна вэ? Тэгээд Цэцийн гишүүн байсан хүн магадгүй ирэх 2028 он хүртэл Улсын Их Хурлаас улс төржсөн шийдвэр гарах олонхоор түрүү барих тийм шийдвэр гарсан тохиолдолд та ямар байр сууриас хандах вэ гэдгийг л асуумаар байна.

О.Номинчимэг: Энэ цэцийн тухай хууль дээр чөлөөлөгдөх юм 3 жил ямар нэгэн албан тушаал хашиж болохгүй гэсэн хууль байхгүй. Тэгээд хууль зөрчсөн хүн байхгүй. Бид энэ хуулийн дагуу энэ хуралдаа явж байгаа гээд хэлмээр байна. Эхлээд Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учрал дарга энэ дээр бас тайлбар өгчихье.

Н.Учрал: Миний хувьд 2016 онд парламентад сонгогдсоноосоо хойш 3 дахь удаагаа ингээд сонгогдон ажиллаж байна. Энэ хугацаанд бол би Их Хурлын Тамгын газрыг дэгийн гол зөвлөх, дээрээс нь улс төрчдөд үгүй гэж хэлж чаддаг хуульчид байгаасай л гэж би боддог. Зүгээр улс төрчдийн дураараа авирласан үгэнд ордог түүнээсээ болж төрийн олон албан хаагч нар дахиж битгий хэлмэгдээсэй гэж би бодож байгаа юм. Тэрнээс биш надад Тамгын даргаар өнөөдөр нэг төрийн албан

хаагч авчраад тавих шиг амархан юм байхгүй. Гэхдээ би өнгөрсөн цаг хугацааны алдааг дахин давтах эрх байхгүй ээ.

Өнөөдөр хэн нэгэн төрийн албан хаагчийг авчраад Тамгын даргаар авчраад сургаж хүмүүжүүлэх цаг алга. Нөхцөл байдлаа хар л даа. Бид нар харах хэрэгтэй. ҮХЦ-ийн гишүүн зөвхөн энэ Үндсэн хуулийг манадаг хамгаалдаг биш шүү дээ. Их хурал өөрөө Үндсэн хуулийг зөрчсөн хууль баталж болохгүй. 2019, 2023 оны үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлах үйл ажиллагааг манлайлж оролцсон хүн бол Өлзийсайхан дарга. Би бас тухайн үед Их Хурлын гишүүн байсан. Ингээд тухайн цаг үед бид хамтарч ажиллаж байсан. Тийм ч учраас би Өлзийсайхан даргыг ямар нэгэн туршлагажих тийм шаардлага байхгүй.

Дээрээс нь Их Хурлаас батлагдаж байгаа хуулийг дахиж Үндсэн хууль зөрчихөөс хамгаалах Үндсэн хуулийн одоо манаанд зогсоосой л гэж би бодож байгаа юм. Их Хурлын гишүүд өнөөдөр 120 зургуулаа болсон. 126 гишүүнтэй болох энэ нөхцөл боломжийг Үндсэн хуулиар олгосон. Энэ үйл явцыг Өлзийсайхан дарга манлайлсан. Нийгэм өнөөдөр 126 гишүүнтэй болсон нь буруу байсан юм биш үү гэж. Пропорциональ систем чинь буруу байсан юм биш үү гэж шүүмжилж байна шүү дээ. Энэ тэгвэл зөв байсан юм уу буруу байсан юм уу гэдгийг Өлзийсайхан дарга өөрөө харуулаасай гэж би бодож байгаа.

Үндсэн хуулиа хамгаалаасай гэж бодож байгаа. Энэ ч утгаараа би дахиж Үндсэн хууль зөрчсөн үйлдэл гаргахгүйн тулд ҮХЦ дээр Үндсэн хуулиа манаж байгаа, хамгаалж байгаа 2019, 2023 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн энэ дэд ажлын хэсгийг нь ахалж байсан хүнийг би Их Хурлын Тамгын даргаар ажиллаач гэж би хүсэлт тавьсан. Миний бас хүсэлтийг харин хүлээж аваад хуульчдын ноён оргил болсон энэ өндөр албан тушаалаас буцаад Тамгын даргаараа ирж энэ Их Хурлынхаа институцийг бас цэгцлэх Тамгын газрынхаа институцийг цэгцлэх ажилд бас бидэнтэй хамтарч ажиллах гэж байгаад нь бид нар олзуурхаад хүлээж авах хэрэгтэй л гэж би та бүхэнд хэлмээр байна.

О.Номинчимэг: 5 номер хүсэлт гаргагч ҮХЦ-ийн гишүүн Өлзийсайхан нэмэлт тайлбар.

Л.Өлзийсайхан: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя аа.

Тэгэхээр миний бие бол Монгол Улсын төрд 27 жил ажилласан. Үүнээс МУИС-д Хууль зүйн сургуульд багш, төрийн үйлчилгээ мөн төрийн захиргаа, төрийн байгууллагууд. Өнөөдөр бол Монгол Улсын ҮХЦ-ийн гишүүнээр ажиллаж байгаа. Энэ бол төрийн тусгай албан тушаал. Тэгэхээр өнөөдөр би энд Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улс өөрөө парламентын БНУ. Парламентын засаглалтай улс. Тэгэхээр тэр улсын парламентын Улсын Их Хурлын дарга санал тавина аа гэдэг надад хүндэтгэлтэй байсан. Миний хувьд угаасаа миний докторын сэдэв. Өнөөдрийг хүртэл би судалж ирсэн сэдэв бол парламентат ёс. Тэгэхээр онолын хувьд болоод бас өмнө нь ажиллаж байсан туршлага маань энэ залуу Улсын Их Хурлын даргад мөн энэ парламентад оруулж байгаа хувь нэмэр болов уу гэж бас бодсон.

Тэгэхээр одоогийн албан тушаал бол төрийн тусгай. Тэгэхээр би одоо бол яг энд Улсын Их Хуралд, түүний Тамгын газарт ЕНБД-ын саналыг хүлээж авч байгаа нь ямар нэгэн би улс төрийн албан тушаал биш төрийн захиргаа. Тэгэхээр би улс

төрийн албан тушаалд би томилогдоогүй. Энэ бол ямар нэгэн эрх мэдэл ямбын асуудал надад тавигдаагүй, надад хариуцлага, итгэл, мөн ажил үүрэг ноогдож байна аа гэж бас ингээд бодож байгаа. Мэдээж хувь хүнийхээ хувьд одоогийн ажил албан тушаалын хувьд би өөрийнхөө энэ ҮХЦ-ийн гишүүн гэдэг энэ ажлаараа бахархдаг. Хуульч хүнийхээ хувьд ч гэсэн би бахархдаг.

ҮХЦ-ийн гишүүн гэдэг энэ бол хуульчдын хуулийг хэрхэн яаж тайлбарлах вэ гэдэг дээр хуульчид өөрөө сургаж байдаг ийм онолын шүүх. Тэгэхээр үүнд бас би томилогдож ажилласан Улсын Их Хуралдаа бас би баярласнаа бас би илэрхийлэх байх. Тэгээд Пүрэвдаваа гишүүний сүүлийн асуултад хариулъя. Миний бие ямар нэгэн улс төр, ямар нэгэн хувийн ашиг сонирхол надад байхгүй. Би юунд захирагдах вэ гэвэл би Монгол Улсын Үндсэн хууль мөн Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд би захирагдана. Би хүнд захирагдахгүй, би хуульд захирагдана аа.

О.Номинчимэг: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ц.Сандаг-Очир: Их Хурлын дарга өөрийнхөө хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Тамгын газрын нарийн бичгийн даргаа хэнээр томилох вэ гэдгээ бүрэн эрхийн асуудал. Гэхдээ бас Цэц дээр 2 жилийн өмнө очоод байж байгаа төрийн өндөр албан тушаалтан тэр дундаа эмэгтэй жендерийн асуудал яривал цөөхөн байдаг энэ төрийн өндөр албан тушаалтнуудаас нэг нь сугалаад ирчихжээ. Тэгээд санал тавьсан юм байна. Саналыг нь хүлээж авч байгаа юм байна. Та бас их азтай эмэгтэй юм. Дарга нар санал тавиад, тавьсан санал болгоныг нь бас хүлээж аваад ингээд. Энэ бол бас хуульчдад тэр дундаа эмэгтэй хуульчдад бас олдоод байдаг ийм аз завшаан гэдэг юм уу боломж биш байх л даа. Энэ түвшинд хүрчих юмсан хуульчаар ажиллах юмсан, Цэцийн гишүүн гэж болчих юмсан гэж хүсэж мөрөөдөж яваа олон хуульч нар, эмэгтэй хуульч нар байгаа л байх. Гэтэл та харин энэ төрийн өндөр албан тушаалууд дунд ингээд хүссэн үедээ тавьсан саналын дагуу очоод байна гэдэг бас азтай нэг талаар. Нөгөө талаар бас ийм мундаг эмэгтэй хуульч юм байна аа гэж ингэж ойлгохоор байна аа.

Их Хурлын даргаас асуухад Цэцийн 9 гишүүн дотор чинь харин бүрэн эрхийн хугацаа нь дуусчихсан гишүүн байгаа юм байна лээ шүү дээ. Энэ хүний асуудлыг яагаад оруулж ирэхгүй байгаа юм. Улсын Их Хурлаас томилогдсон субъект. Их хурал, өөрөө мэдэх ёстой. Дөнгөж бүрэн эрх нь хэрэгжээд хоёрхон жил болж байгаа хүнийг сугалаад татчихлаа. Харин бүрэн эрх нь дуусчихсан байгаа хүнийг ажлыг нь дуусгавар болгоод хуулиа бариад ингээд орных нь хүнийг оруулж ирэх асуудал харин яригдах ёстой байсан юм биш үү. Энэ хүний асуудлыг хэзээ оруулж ирэх юм бэ? Тэнд бас хууль зөрчигдөөд яваад байгаа асуудал байгаа юм биш үү гэдгийг л асууя даа. Тэрнээс өөр нэр дэвшигчийн хувьд бол тавьсан саналыг нь хүлээж авч байгаа, ажлаасаа чөлөөлөгдье гэж байгаа хүнтэй юу ярих вэ? Өөрөө хүлээн зөвшөөрч байгаа бол. Санал болгож байгаа Их Хурлын даргаас асууя.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учрал.

Н.Учрал: Хугацаа нь дууссан Цэцийн гишүүдийг оруулж ирнэ. Тэгээд хуулийнхаа хүрээнд ажиллана. Тэгээд Их Хурал 3 цэцийн гишүүнийг санал болгож томилуулсан. Тэгээд хуулиараа ч гэсэн санал болгож байгаа байгууллага нь өөрөө хүсэлтийг нь хүлээж аваад эсвэл хугацаа сунгаж дууссан бол дараагийн нэр дэвшигчийг оруулж ирээд томилох ийм хуультай. Тэгээд үе шаттай ажлууд өрнөнө.

Тэгээд ажил аваад удаагүй байна. Би юутай ч нэг Тамгын даргаа томилоод ажил руугаа оръё гэж бодож байна. Яг энэ тамгынхаа бүтэц, зохион байгуулалт руу. Тэгээд алдаа гаргах эрхгүй ийм хариуцлагатай цаг үед бол байна аа. Тэгээд би өөрөө бас хэдийгээр улс төрийн хувьд 3 удаа сонгогдсон Байнгын хорооны даргаар ажиллаж байсан. Хоёр Үндсэн хуулийг батлалцахад оролцсон туршлага байгаа хэдий ч бас залуу хүн.

Тэгэхээр бас залуу парламентын даргын хувьд бас эрх барьж байгаа намын даргын хувьд ч гэсэн надад хууль зөрчсөн үйлдэл гаргахгүй байх. Дээрээс нь би Их Хурлыг улс төржүүлэхгүй байхаас сэргийлж байна. Тэрнээс биш би нэг намынхаа нэг нөхрийг авчраад Тамгын даргаар тавивал тавьчихна л даа. Тэгэхдээ би тэгэхийг хүссэнгүй. Улс төржүүлэхийг би хүссэнгүй. Би үг хэлэх үзэл бодлоо илэрхийлэх, олон намын олон ургалч үзэл бүгдэд нь тэгш хандана. Би парламентын спикерийн хувьд тэгш хандана.

Тэгэхээр миний ар тал энэ Тамгын газрын дэг сахиулах үйл явц хуулийн хүрээнд ямар ч асуудалгүй өрнөх ёстой. Тийм учраас одоо би өөрөө хүсэлт тавьсан юм аа.

Тэрнээс биш энэ Өлзийсайхан даргын буруу зүйл байхгүй. Өлзийсайхан дарга Их Хурлын дарга хүсэлт тавихаар ингээд шийдвэрээ гаргасан байх л даа. Тэгэхдээ бүгдээрээ бас 2019, 2023 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амилуулах хэрэгтэй. Чамд парламентыг төгөлдөржүүлэхэд их л том хувь нэмрээ оруулсан нэмэлт, өөрчлөлт гэж яриад байсан чинь сүүлийн үед ер нь энэ 2 Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэ 126 гишүүнтэй болсон чинь зөв байсан юм уу гэдэг ийм дүгнэлт рүү хүргэж болохгүй шүү дээ. Миний итгэл үнэмшлийн хувьд би 126 парламентын гишүүнтэй болсон нь пропорционал тогтолцоо нэвтэрсэн нь маш зөв гэж боддог.

Тэгэхээр би энэ итгэл үнэмшлээ илүү нийгэмд болоод бусад улс төрийн намууд ч гэсэн баталгаажуулах хүрээндээ хуулийн ямар нэгэн зөрчил гаргахгүйгээр үйл ажиллагаагаа явуулъя аа гэж би хүссэн. Тэрнээс биш Өлзийсайхан даргын хувьд бол Цэцийн гишүүнээс чөлөөлөгдөөд энд ирэх хувь хүний хувьд бол маш хүнд шийдвэр. Тийм учраас бас ажиллая гээд эрмэлзэл байгаа учраас бид дэмжээд ажиллуулах нь цаашдаа Их Хурлын үйл явцад хэрэгтэй.

О.Номинчимэг: Гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлдье.

Лувсандоржийн Өлзийсайханыг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Монгол Улсын ҮХЦ-ийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

14 гишүүнээс 12 гишүүн буюу 85.7 хувиар дэмжигдлээ.

ҮХЦ-ийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

ҮХЦ-ийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцсэн талаар ХЗБХ-ны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ?

Даваагийн Цогтбаатар гишүүн танилцуулна аа.

Байнгын хорооноор хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

10.31 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА